



ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

Хичээлийн байрны өргөтгөл С байр ашиглалтанд орлоо

Мандах их сургуулийн барилгын төсөл 2017 онд эхлэж, хичээлийн байрны А, В блокын барилгыг 2018 оны 8 сард ашиглалтад оруулж байсан бол 2019 оны сүүлчээр хичээлийн байрны С блокын таван давхар барилгыг ашиглалтад оруулан, сургалтын тавилга хэрэгслээр иж бүрэн тоноглон тохижуулж 2020 оны 01 сарын 16-ны өдөр нээлтээ хийлээ. Энэхүү С блокын барилга ашиглалтад орсноор 550 оюутны суудал бүхий хичээлийн 11 танхим, 130 суудалтай хурлын танхим, оффисын өрөөнүүд шинээр нэмэгдэн оюутан, багш ажиллагсадын суралцах, ажиллах тав тухтай орчинг нэмэгдүүлэн, материаллаг баазыг бэхжүүлсэн чухал ажил боллоо. Тус барилгын ерөнхий гүйцэтгэгчээр Р.Хангай захиралтай Гантоонот констракшн компани ажиллаж, барилгыг зураг төслийн дагуу чанарын өндөр түвшинд барьж гүйцэтгэн хүлээлгэн өглөө

Эрдэм шинжилгээний “Мандах эрдэм” сэтгүүлийн гурав дугаар хэвлэгдэн гарлаа

“Мандах их сургуулиас “Мандах судалгаа” олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлийн хоёрдугаар дэвтрийг гаргалаа. Тус сэтгүүлд олон салбарын эрдэмтэн судлаачдын бүлгүүд, их сургуулийн багш нарын олон сэдвээр бичсэн 12 шинжлэх ухааны өгүүллийг багтаасан байна.



Мандах их сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний хурал боллоо

Мандах Их Сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний хурал 2020 оны 01 сарын 13-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө. Энэхүү эрдэм шинжилгээний хурал нь багш нар харилцан мэдлэг туршлага солилцох, хамтарсан судалгаа шинжилгээний ажлыг дэмжих таатай нөхцөл бүрдүүлж байгааг тэмдэглүүштэй. Энэ удаагийн эрдэм шинжилгээний хурал 5 судалгааны багаас шалгарсан 11 илтгэлийг танилцуулж хэлэлцүүлээ.

Мандах Их Сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний хуралд илтгэлээ хэлэлцүүлсэн судалгааны баг, багш нарыг тодотговол:

I. Эдийн засаг, бизнесийн судалгааны баг

“Мөнгөний нийлүүлэлт ба эдийн засгийн өсөлтийн инфляцид үзүүлэх нөлөөлөл”

Л.Дансранбавуу /Багш/, С.Мөнхцэцэг /Ахлах багш/, Б.Нацагдорж /Доктор, профессор/

“Үүрэн холбооны зах зээлийн хэрэглэгчийн үнэнч байдлын түвшинг тодорхойлох нь”

Б.Сайнжаргал /Багш/, П.Насанжаргал /Багш/, М.Жанузах /Багш/, Г.Билгээ /Доктор, дэд профессор/

“Санхүүгийн эрсдлийн шинжилгээний арга зүйн зарим асуудал”/МЦХ ХК-ны жишээн дээр/

С.Цолмон /Доктор (PhD), дэд профессор/, Ж.Гантулга /Багш/, Г.Эрдэнэцогт /

Багш/, Г.Уянга /Багш/

II. Бүртгэл, санхүүгийн судалгааны баг

НББОУС40“Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө” стандартын нэвтрэлт, хэрэгжилтийн судалгаа

Х.Нямбаяр /Дэд профессор/, М.Энхсүрэн /Ахлах багш/, Г.Хандсүрэн /Багш/

“Багшийн ур чадварын үнэлэмж, анхаарах асуудал” Д.Цэвэлмаа /Ахлах багш/

“СТОУС15 худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого стандартын нэвтрэлт, хэрэгжилтийн судалгаа”/Барилгын салбарт/ Б.Баатарцогт /Багш/

III. Хүмүүнлэг, боловсрол судлалын судалгааны баг

“Монгол хэлний үндэсний онцлог үгийг хэрэглээ талаас судлах нь”

/”Нохой хорио” үгийн жишээн дээр/ И.Должинсүрэн /Багш/

“Оюутны англи хэлээр сонсож ойлгох хүчин зүйлсийн судалгаа” Т.Оюунтогтох /Багш/

“Z үеийнхэний онцлогийг сургалтанд харгалзан үзэх нь” З.Тэлмүүн /Багш/

IV. Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн судалгааны баг

“Монголчуудын ургийн овгийн хэрэглээний байдал” О.Баттуяа /Доктор /

V. Мэдээллийн технологийн судалгааны баг

“Django framework” П.Зоригтбаатар /Багш/



Дотоод хамтын ажиллагаа

“Нандин Бродерс Групп” ХХК-наас Их Дээд Сургуулиудын оюутнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ШИЛДЭГ БИЗНЕС ТӨСӨЛ” шалгаруулах тэмцээнд амжилттай оролцлоо.

Жил бүр “Нандин Бродерс Групп” ХХК-наас зохион байгуулдаг “Шилдэг Бизнес Төсөл” шалгаруулах тэмцээн нь дараах зорилгын хүрээнд явагддаг. Оюутан залуучуудын бизнес сэтгэлгээний өнөөгийн чиг хандлагыг судлан, шилдэг төслийг хэрэгжүүлэх Групп компаний хэмжээнд боловсон хүчин бэлтгэх

Нийгмийн хариуцлагын хүрээнд шалгарсан оюутнуудыг сургалтын төлбөрөөр дэмжин бизнес санаагаа ажил хэрэг болгох хүсэл тэмүүлэлд хөтлөх

Дээрх зорилгын хүрээнд зохион байгуулсан тэмцээн нь 2019.09.20-ноос 12 сарын 15-ны хооронд нийт 55 хоног үргэлжилсэн тэмцээн болсон ба нийт 6 сургуулийн 18 баг өрсөлдсөнөөс 1-р шатанд МУИС-БС, ХААИС, СЭЗИС, ШУТИС-ын БУХИС, Мандах Их Сургуулийн 6 багийн төсөл шалгарч 2-р шатанд тэнцсэн. Мандах Их сургуулийн 1-р баг болох “Cashmere Gold” багийн ахлагчаар НББ-Англи хэл 4-р курсын Цагаанхүү, гишүүнээр НББ-татвар 3-р курмсийн Өсөхбаяр, НББ-татвар 4-р курсын оюутан Энхтөр, 2-р баг болох “Seabucktorn”-ийг НББ-Татвар 4-р курсын Дэлгэрмаа ахлаж, гишүүдээр НББ-Татвар 4-р курсын Жамьяанцэрэн, НББ-Татвар 3-р курсын Түвшинтөр нар оролцож, 1-р баг болох “Cashmere Gold” нь 2-р байр эзэлсэн бол 2-р баг “Seabucktorn” нь тусгай байр эзлэж нийт оюутнууд 2 сая /хоёр сая/ төгрөгөөр шагнуулсан. Мөн ажлын байрны санал хүлээн авсан болно. Удирдагч багшаар ЭЗБТ-ийн багш Б.Сайнжаргал, М.Жанузах нар хамтран ажиллалаа.



Үйл явдлууд

Мандах Их Сургууль үүсэн байгуулагдсны 28 жилийн ой тохиож байна

Мандах Их Сургуулийн захирал Г. Нанжид хамт олондоо цахим мэндчилгээ дэвшүүллээ.

Манлайлагч Мандахчууд та бүхэндээ түүхт өдрийн баярын мэндийг өргөн дэвшүүлье. Жил бүрийн 05 дугаар сарын 08 бол бидний хувьд сургууль байгуулагдсан баярын өдөр байдаг. Энэ жил сургуулийн маань 28 жилийн ой тохиож байна. Энэ удаагийн баяр цар тахалтай хүнд үед тохиож байгаад харамсалтай байна. Гэвч манай хамт олон болон Монголын олон түмэн маань энэхүү хүнд цаг үеийг эндэлгүй давж, амар тайван сайхан цагтай удахгүй золгоно гэдэг итгэлтэй байна.

Манай хамт олон энэ хичээлийн жилийн II улирлын хичээлийг цахим хэлбэрт шилжүүлэн өнөөдрийг хүртэл амжилттай тасралтгүй явуулж байна. Манай багш нар хичээлээ тасралтгүй амжилттай явуулахын тулд ихээхэн хүчин чармайлт, цаг хугацааг зарцуулж уйгагүй ажиллаж байгаад нийт оюутнуудынхаа өмнөөс талархал дэвшүүлье.



Үйл явдлууд

Онцгой байдлын үед Мандах Их Сургууль цахим сургалтын системээ ашиглан сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна.

Дэлхий нийтэд тархаад буй COVID-19 цар тахлын үеийн онцгой байдлын хорио цээрийн дэглэмийг Улсын Онцгой Комиссын 2020 оны 03 сарын 20-ны өдрийн 13-р хуралдаанаас 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасантай холбогдуулан Мандах Их Сургуулиас цахим сургалтын систем/online.mandakh.org/-ийг ашиглан сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна. Мандах Их Сургууль уг системийг 2016 оноос эхлэн магистр, доктор, эчнээ сургалтын хөтөлбөртөө ашиглаж танхимын болон зайн сургалтыг хослуулан явуулж ирсэн. Энэ онцгой нөхцөл байдлын үед уг системийг улам өргөжүүлэн хөгжүүлж бакалаврын өдрийн хөтөлбөрийн сургалтыг цахимаар явуулж байна. Сургуулийн захиргаанаас онцгой байдлын үед суралцагсдад үзүүлэх сургалт, судалгааны ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, сургалтын үйл ажиллагаанд баримтлах удирдамж боловсруулан түүний дагуу багш нар танхимийн сургалтаар өгдөг бүх сургалтын үйл ажиллагаа /лекц, семинар, бие даалт, судалгааны ажил гэх мэт/-г цахимд шилжүүлж, бүх хичээлээр видео лекц, семинар, бататгах хичээл бэлтгэн хичээлийн хуваарийн дагуу зөвөлгөө өгч ажиллаж байна. Төгсөх дамжааны оюутнуудын хувьд төгсөлтийн шалгалтанд бэлтгэх хичээлийг цахим сургалтын системд оруулан зөвөлгөө өгөх, хамгаалуулах зөвлөлөөс оюутнуудын дипломын ажлын явцын үзлэг, урьдчилсан хамгаалалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, удирдагч багш нар оюутнуудтай байнга харилцан судалгааны ажилд чиглэл зөвлөмж өгч дэмжин ажиллаж байна. Цахим сургалтын системийн хандалт, судалгаагаар нэвтэрсэн оюутны тоо өндөр байгаа нь онцгой байдлын үед тус сургуулийн оюутнууд ёс зүйтэй, хариуцлагатай хандаж сурах эрмэлзэл дүүрэн буйд сургуулийн захиргаа, эрдэмтэн багш, ажилтнууд талархалтай байна.



Уралдаан тэмцээн

Мандах Их Сургуулийн I дамжааны оюутнуудын дунд зохиогддог “English-Culture” онлайн тэмцээн боллоо

Энэхүү өдөрлөгийн зорилго нь оюутнуудын гадаад хэл сурах авьяасыг нээн илрүүлэх, англи хэл сурах идэвх сонирхлыг нэмэгдүүлэх, амжилтыг урамшуулах, мэдлэгийг хөхүүлэн дэмжих, хичээлээр эзэмшсэн мэдлэг, дадал, туршлагаа бусадтай хуваалцахад оршино.

Мандах Их Сургуулийн ГХТ-ээс жил бүр уламжлал болгон 1-р дамжааны оюутнуудын дунд зохион байгуулагддаг энэхүү тэмцээнийг 2020 оны 04 сарын 10-ны 11 цагт анх удаа цахимаар багш И.Должинсүрэн, З.Тэлмүүн нар тэнхимийн багш нарын хамтаар амжилттай зохион явууллаа. Тэмцээнд 150 оюутан оролцож 4 төрлөөр өрсөлдлөө.

Асуулт хариултын тэмцээнд

1-р байр – НББ-Татвар 1-1 ангийн оюутан Ганбатын Сарантунгалаг

2-р байр – НББ-Татвар 1-2 ангийн оюутан Тилеубэкийн Асель

3-р байр – Санхүүгийн менежментийн 1-2 ангийн оюутан Ганхуягийн Хүслэн.

Үг үсэглэх тэмцээнд

1-р байр – НББ-Аудит 1-1 ангийн оюутан Ууганбаатарын Оюунбилэг

2-р байр – НББ-Аудит 1-1 ангийн оюутан Цэцэгдэлгэрийн Отгонцэнгэл

3-р байр – НББ-Аудит 1-1 ангийн оюутан Болор-Эрдэнийн Намуунзул

Орчуулгын тэмцээнд

1-р байр – Санхүүгийн менежмент 1-2 ангийн оюутан Зоригоогийн Маралгоо

2-р байр – НББ-Татвар 1-1 ангийн оюутан Нямбаярын Уянга;

3-р байр – НББ-Татвар 1-1 ангийн оюутан Маралхүүгийн Эрдэнэ.

Англи дууны тэмцээнд

1-р байр – НББ-Аудит 1-1 ангийн оюутан А. Энхсоёл

2-р байр – Санхүүгийн менежмент 1-1 ангийн Г. Анхбаяр

3-р байр – НББ-Татвар 1-2 ангийн оюутан Э.Болорцэцэг, Ө.Хандармаа (Хамтлаг дуу)



ТАЛАРХАЛ

Сайн байцгаана уу? Эрдэмтэн багш нар, ажилтан албан хаагчид, оюутан залуус та бүхэндээ хаврын урь орсон сайхан өдрийн мэндийг хүргэе. Намайг Б.Анхзаяа гэдэг. 2014 онд БЭЗНББ-н ангийг Ш.Цэцэгжаргал багшийн удирдлаган доор төгсөж байлаа. Миний бие төрөлхийн нурууны муруйлт /scoliosis/ оноштой байсан бөгөөд олон жил энэхүү өвчнөөрөө өвдөж шаналж хагалгаанд орж эрүүл саруул болох юмсан гэж хүсч мөрөөдөж байлаа. 2019 оны 7 сард Турк улсад энэхүү хагалгаа хийгддэг талаар мэдэж 11 сард зориг гарган шийдвэр гаргасан юм. Та бүхэн санаж байгаа байх. 2019 оны 11 сард пэйжээ нээн "Заяадаа тусалцгаая" хандивын аян зарласан байсныг Г. Хандсүрэн болон Ш. Цэцэгжаргал багш нар маань өгөөмөр сэтгэл гарган сургууль дээр хандивын аяныг өрнүүлэн та бүхэн минь идэвхтэй оролцож сайхан сэтгэлийн гараа сунгаж тусалсанд би чин сэтгэлийн гүнээс талархал илэрхийлж байна. Та бүхнийхээ туслалцаатайгаар Турк улсын Истанбул хотын Лив эмнэлэгт 1 сарын 31-нд нуруу тэгшлэх эхний хагалгаанд /4цаг/, 2 сарын 7-нд 2 дахь хагалгаандаа /6цаг/ амжилттай орсон бөгөөд хагалгааны явцад ч тэр одоо ч тэр миний бие маш сайн байгаа. Хагалгааны үр дүнд нуруу маань тэгширч, 10 см өндөр болсон.

Та бүхний минь хийсэн буян будаа шиг үржин эргээд таны амьдралд аз жаргалыг авчрах болтугай. Сурлага хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.

**Редакцийн зөвлөл:**

Ч.Төрбадрах / Сургалт эрхэлсэн дэд захирал /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

С.Булганаа / Гадаад хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.edu.mn

Г.Энхжин /Номын санч/
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn